



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХЭТ ЖИЖИГЛЭЖ,
ТУХАЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВТ ТУСГАЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ
УРСГАЛ ЗАРДАЛД БОЛОН ЖУРАМД ТУСГАГДААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД
ТӨЛӨВЛӨН ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮР ӨГӨӨЖИЙГ
БУУРУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: ЗАА-2024/11-ШТА-ГА



Улиастай хот
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Оюунсүвд
Утас: 99076038, Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Аудитор Г.Баасанжаргал
Утас: 99032514, Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.open.audit.mn

АГУУЛГА

Тушаал	2
Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээлэл.....	4

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРЭН БҮРДҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН 4 МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРААС ТӨВЛӨРӨХ ОРЛОГО БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....5-7

1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг шат шатны ИТХ-аас батлахдаа иргэдээс санал авч эрэмбэлээгүй, урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна7-9

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 6.6 ХУВЬ НЬ ДУТУУ 11.5 ХУВЬ НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр журамд нийцээгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.....10-13

2.2 ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь тус сангийн үр дүн, үр нөлөөг бууруулж байна.....13-15

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.....15-16

БҮЛЭГ 3. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ СУЛ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН ЧАНАРТ СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад тавих шат, шатны ИТХ-ын хяналт хангалтгүй байна.....16-17

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг, заавар журмын дагуу холбогдох газарт хүргүүлээгүй байна.....17-19

ДҮГНЭЛТ20-21

ЗӨВЛӨМЖ22-23

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР24-25



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/28

Улиастай

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4, 2.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Оюунсүвд)-т даалгасугай.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Оюунсүвд)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Audit(D)тушаал-2024

9. 4. 172

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТТХ	Төсвийн тухай хууль
АОНХС	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ХХАА	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ

Хүснэгтийн товъёг

Хүснэгт-1	Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг
Хүснэгт-2	Орон нутгийн хөгжлийн санд төвлөрч буй бусад орлого
Хүснэгт-3	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

Дүрслэлийн товъёг

График-1	Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл
График-2	АОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл
График-3	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

**Аудитын хамарсан
хүрээ**

Тус аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг хорооны Засаг дарга, аймаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлэн, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан, зөвлөмж бэлтгэлээ.

**Аудитын багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Г.Баасанжаргал нар аудитыг гүйцэтгэлээ.

Аудитыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлүүлж, хөтөлбөрт заасан хугацаанд холбогдох үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын тайланг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт нэгтгүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРЭН БҮРДҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН Ч МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРААС ТӨВЛӨРӨХ ОРЛОГО БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙНА.


1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлжээ.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Завхан аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг анх 11,932.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 3,110.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 15,043.1 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасны дагуу орлогын эх үүсвэрийг улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгээс 14,248.5 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 63.2 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 115.9 сая төгрөг, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу “Тогтвортой амьжиргаа-3” төслийн урамшууллаас 615.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

График-1



Хуваарилагдсан төсвийг 6,953.9 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 24 сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлэгт 8,089.2 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-ын 2023 оны 81 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна.

1.1.2. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-аар Сангийн яамнаас тооцоолсны дагуу хуваарилж, олгосон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 6,953.9 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн ч Сангийн яамнаас орлогын шилжүүлгийг 207.0 сая төгрөгийг дутуу олгосон байна.

1.1.3. Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

Аймгийн ОНХС-аас сумдад хуваарилсан орлогын шилжүүлэг 8,089.2 сая төгрөгийг хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

Хүснэгт-1 Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг /сая төгрөг/

№	Сумын нэр	Орлогын шилжүүлэг	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Тогтвортой амьжиргаа-3 төсөл" урамшуулал	ОНХС-ийн нийт эх үүсвэр
1	Алдархаан	319.6	-	-	-	319.6
2	Асгат	112.0	7.7	-	-	119.6
3	Баянтэс	379.3	-	-	41.6	420.9
4	Баянхайрхан	235.1	1.5	-	32.8	269.3
5	Дөрвөлжин	342.7	8.6	70.2	-	421.4
6	Завханмандал	202.3	9.6	10.9	-	222.8
7	Идэр	230.3	-	-	30.7	261.0
8	Их-Уул	699.3	-	-	71.3	770.5
9	Нөмрөг	250.0	-	-	23.9	273.8
10	Отгон	321.1	-	-	35.9	357.1
11	Сантмаргаз	216.8	11.9	0.8	-	229.5
12	Сонгино	203.3	3.2	0.0	22.9	229.4
13	Тосонцэнгэл	954.2	-	8.6	93.2	1,056.0
14	Тэс	335.0	-	-	-	335.0
15	Тэлмэн	272.5	-	-	43.5	316.0
16	Түдэвтэй	271.9	-	-	24.4	296.3
17	Улиастай	632.9	-	-	85.2	718.1
18	Ургамал	205.6	18.5	10.3	-	234.4
19	Цагаанхайрхан	134.4	-	-	17.2	151.6
20	Цагаанчулуут	140.8	-	-	18.7	159.5
21	Цэцэн-Уул	206.7	-	-	23.3	230.0
22	Шилүүстэй	186.8	2.4	-	20.7	209.9
23	Эрдэнэхайрхан	214.0	-	15.0	-	229.1
24	Яруу	228.2	-	-	30.1	258.4
Дүн		14,248.6	63.2	115.9	615.3	8,089.2

1.1.4 Малын тоо толгойн албан татварын орлогыг тооцож, төлөвлөсөн боловч тус орлого бүрэн бүрдээгүй байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд нийт 3,020.5 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Аймгийн ОНХС-д 200.0 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогоос олгосон байна.

Бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн орлогыг төрөл тус бүрээр нь авч үзвэл:

Хүснэгт-2 Орон нутгийн хөгжлийн санд төвлөрч буй бусад орлого /сая төгрөг/

№	Сум, дүүргийн нэр	ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл		ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"		Өвс тэжээлийн орлого, бусад орлого		Малын тоо толгойн албан татвар		Нийт дүн
		төлөв	гуйц	төлөв	гуйц	төлөв	гуйц	төлөв	гуйц	
1	Алдархаан	137.5	62.8	50.0	-	-	-	-	-	187.5
2	Асгат	45.0	40.8	-	-	-	1.3	7.0	4.2	52.0
3	Баянтэс	48.0	-	-	-	-	0.1	30.4	23.4	78.4
4	Баянхайрхан	27.3	-	-	-	-	46.6	53.0	47.0	80.3
5	Завханмандал	14.1	40.0	-	-	-	1.1	20.0	40.0	34.1

6	Дөрвөлжин	310.1	-	-	-	-	-	33.0	-	343.1
7	Идэр	15.0	15.0	-	-	-	-	24.0	24.0	39.0
8	Их-Уул	-	-	30.0	25.3	-	1.0	55.0	48.7	85.0
9	Нөмрөг	39.2	-	-	-	-	0.1	30.0	11.0	69.2
10	Отгон	26.0	-	27.5	-	-	0.1	57.5	55.2	111.0
11	Сантмаргаз	-	-	-	-	-	0.2	28.0	15.4	28.0
12	Сонгино	178.6	224.2	-	-	-	-	65.0	47.5	243.6
13	Тосонцэнгэл	415.4	375.3	-	-	-	-	105.5	36.3	520.9
14	Тэс	64.3	-	-	-	-	-	20.0	20.0	84.3
15	Тэлмэн	58.8	93.9	-	-	-	-	48.0	-	106.8
16	Түдэвтэй	-	-	-	-	-	-	60.0	29.1	60.0
17	Ургамал	17.6	6.4	-	-	-	-	22.4	38.6	40.0
18	Улиастай	314.7	280.0	-	-	-	-	15.0	15.0	329.7
19	Цагаанхайрхан	43.5	24.0	-	-	-	-	15.0	22.3	58.5
20	Цагаанчулуут	17.8	21.1	-	-	-	15.5	12.0	10.7	29.8
21	Цэцэн-Уул	25.2	-	-	-	-	15.9	26.0	19.0	51.2
22	Шилүүстэй	14.3	48.7	-	-	-	16.1	16.0	17.3	30.3
23	Эрдэнэхайрхан	116.4	31.7	-	-	-	0.0	36.0	31.4	152.4
24	Яруу	5.2	-	-	-	-	-	-	-	5.2
25	Аймгийн ОНХС	-	-	-	200.0	-	-	-	-	200.0
Нийт дүн		1,934.1	1,263.8	107.5	225.3	-	97.9	778.8	556.1	3,020.5

Малын тоо толгойн албан татвараас 778.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөсөн боловч 599.0 сая төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэл 76.9 хувьтай байна. Иймд Малын тоо толгойн албан татварыг төлөвлөсөн хэмжээнд оруулж, ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөн ОНХС-ийн хөрөнгөөс нөөц бүрдүүлж худалдан авсан өвс, тэжээлийн орлогыг санд буцаан төвлөрүүлэхээр төлөвлөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянтэс, Сантмаргаз, Дөрвөлжин, Алдархаан сумд ОНХС-ийн хөрөнгөөс нөөц бүрдүүлж худалдан авсан өвс, тэжээлийн орлогыг санд буцаан төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг шат шатны ИТХ-аас батлахдаа иргэдээс санал авч эрэмбэлээгүй, урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

1.2.1 Сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 сарын 17-ны өдрийн А/424 дүгээр захирамжаар ажлын хэсгийг байгуулж Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлд заасны дагуу АОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн төлөвлөж, сумдаас ирүүлсэн төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлого чиглэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэхийг тооцож урьдчилсан жагсаалтыг эрэмбэлсэн боловч иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг огт хийгээгүй байна. Цаашид урьдчилсан жагсаалтыг эрэмбэлсэн олон нийтээр хэлэлцүүлж, үр дүнг нэгтгэж ажиллах шаардлагатай байна.

Багуудын ИНХ-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, эрэмбэлэхтэй холбоотой баримт материалыг шалгахад хугацаандаа хуралдаагүй, ирц бүрдээгүй, саналын хуудсыг бүрэн бөглөөгүй, авсан саналд сумын хөдөлмөрийн насны хүн амын 17-47.8 хувь хамрагдаж байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.1, 5.8 дахь заалтыг зөрчиж байна. Иргэдээс санал авах ажил нэр төдий хийгдэж, ОНХС-ийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, саналыг хүртээмжтэй байдлаар авах, журамд заасан цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр ашиглан оролцоог хангаж ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, аймаг, сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.2.3 ОНХС-ийн хөрөнгөөр техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 19,653.7 сая төгрөгийн 857 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, аймгийн ОНХС нь ТЭЗҮ, тооцоо судалгаа хийгдээгүй 292.7 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, төлөвлөсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аас батлахдаа урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумдаас ирүүлсэн саналыг тусгадаг боловч аймгийн ИТХ-аас төлөөлөгчдийн саналыг тусгаж баталдаг зөрчил байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээс санал авч, эрэмбэлээгүй, ТЭЗҮ, тооцоо судалгаа хийгдээгүй 6,126.5 сая төгрөгийн 338 төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 60 дугаар зүйлийн 60.3.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуурыг баримтлаагүй ТЭЗҮ хийгдээгүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө бэлтгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Аудитын илрүүлэлт:

Иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ, тооцоо судалгаагүй төсөл, арга хэмжээг баталсан зөрчилд аймаг, сумдын ИТХ болон аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2.4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 254.9 сая төгрөгийн 38 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС: Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 5,658.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 78 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр анх баталж, аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор тодотгож, 24 төсөл арга хэмжээг 1,555.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр нэмж баталсан байна. Үүнээс 215.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж, 7,635.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 97 нь шинээр эхлэх төсөл, арга хэмжээ байна. Эдгээр нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарах, журамд нийцсэн төсөл, арга хэмжээ байна.

Сумдын ОНХС: Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 12,018.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 757 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй, журам зөрчсөн дараах төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Отгон сум "Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа" зохион байгуулахаар баталж, сумын 100 жилийн ойн баримтат кино, түүхэн номын урьдчилгаа, Малчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 11.0 сая төгрөг зарцуулсан;
- Тэс сум ИТХ-ын төлөөлөгчдийг сургалтад хамруулах, "Төлөөлөгчийн нэг өдөр арга хэмжээ зохион байгуулах", ЗДТГ-т тавилга худалдаж авахад 32.9 сая төгрөг, Тэлмэн сум ахмадын байгууллагад дэмжлэг, Эх хүүхдийг дэмжих сан, Орон нутаг хамгаалалтын зардал, Газарзүйн нэршил өөрчлөх, Жишиг хашаа барих зэрэгт 34.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Тосонцэнгэл сум хог хаягдлын байцаагчийн урамшуулал, "Шагж" аваргын бөхийн барилдаан, 100 жилийн ойн баяр наадмын шууд дамжуулалт, сур харвааны холимог багийн шагнал, 100 жилийн сэтгүүл, 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд "Өв соёл" арга хэмжээ, Малчдын зөвлөгөөн зохион байгуулахад 73.5 сая төгрөг зарцуулсан;
- Ургамал сум эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран ажиллах, Сумын хөгжлийн төлөвлөгөөний судалгааг эхлүүлж, 100 жилийн ойн номны эх бэлтгэл хийх, ЗДТГ-т бараа материал худалдаж авахад 15.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Улиастай сум шүүхийн шийдвэрийн өр төлбөр, сургууль, цэцэрлэгийн дэмжлэг, авлигын эсрэг үйл ажиллагаа, ногоо гэрэл цагаан шугам үйл ажиллагаа, бизнес эрхлэгчдийн уулзалт, хэлэлцүүлэгт 29.2 сая төгрөгийг зарцуулсан;
- Баянтэс сум малчдын зөвлөгөөнд 5.9 сая төгрөгийг, Цэцэн-Уул сум малчдын зөвлөгөөн зохион байгуулж, 5.0 сая төгрөг зарцуулсан байна.

Мөн Алдархаан, Баянхайрхан, Тэлмэн, Ургамал, Яруу сумд гамшгийн сан, эрсдэлийн сан, орон нутгийн нөөц сан зэрэг ОНХС-ийн хөрөнгөөр сан байгуулж, нохой устгал, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, ахмадын хороонд дэмжлэг үзүүлэх, мал тооллого, шүлхийн вакцины шатахуун, мал баригчийн хөлс зэрэгт 47.2 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.3.1, 60.3.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7.1, 4.7.5, 4.7.6 дахь заалтыг зөрчиж байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй, журам зөрчсөн төсөл, арга хэмжээг, төлөвлөж зарцуулсан зөрчилд 252.6 албан шаардлага өгөхөөр, Ургамал сумын ОНХС-ийн хөрөнгөөс бөхийн зодог шуудаг худалдаж авсан 2.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 6.6 ХУВЬ НЬ ДУТУУ 11.5 ХУВЬ НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр журамд нийцээгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

2.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн ОНХС: Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 4,574.4 сая төгрөгийн 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Харин хөрөнгө оруулалтын 87.8 сая төгрөгийн зураг төсвийн ажилд тендер зарлаж худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчилд 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгсөн.

Сумдын ОНХС: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 4,373.1 сая төгрөгийн 77 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийх зорилгоор ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг хэт жижиглэж, төсөвт өртгийг босго үнээс багасгаж батлах зөрчил нийтлэг байна.

2.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 79.3 хувьтай байна.

ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл 1,945.1 сая төгрөг, тайлант онд нийт 15,336.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 16,475.7 сая төгрөгийг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 2,751.0 сая төгрөг болсон байна. ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 857 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 19,653.7 сая төгрөгийг баталснаас 15,578.2 сая төгрөгийн 671 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1,255.0 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжиж, 2,177.5 сая төгрөгийн 120 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Хүснэгт-3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сумдын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алдархаан	50	558.9	25	283.4	1	10.0	12	257.3
2	Асгат	14	183.9	11	97.6			4	79.8
3	Баянтэс	29	499.3	24	433.0	1	5.0	2	20.0
4	Баянхайрхан	24	393.9	18	280.6	1	60.0	5	45.0
5	Завханмандал	24	357.8	22	286.2	-	-	2	37.0
6	Дөрвөлжин	31	822.0	19	277.1	4	339.2	8	182.5
7	Идэр	14	315.0	11	184.9	3	127.1	0	-

8	Их-Уул	46	855.5	44	820.7	1	15.0	1	11.0
9	Нөмрөг	27	303.5	24	248.7			3	43.7
10	Отгон	31	506.0	20	247.8	2	20.0	9	208.8
11	Сантмаргаз	13	294.8	9	182.2	1	14.0	3	91.2
12	Сонгино	26	498.1	26	448.7				
13	Тосонцэнгэл	71	1,801.9	58	1,499.6	4	229.5	9	110.8
14	Тэс	43	425.1	29	276.8	3	34.0	11	104.9
15	Тэлмэн	49	539.2	42	417.2			7	71.7
16	Түдэвтэй	22	356.3	18	220.4			4	90.9
17	Ургамал	43	305.6	18	185.2	2	29.9	6	19.3
18	Улиастай	80	1,057.1	77	1,026.0			3	78.5
19	Цагаанхайрхан	26	232.6	18	129.0			8	83.0
20	Цагаанчулуут	18	224.0	15	196.2	-	-	3	17.3
21	Цэцэн-Уул	25	354.5	15	142.4	1	24.4	9	168.6
22	Шилүүстэй	15	355.3	14	303.2			1	33.2
23	Эрдэнэхайрхан	23	494.4	12	240.0	3	51.0	8	193.4
24	Яруу	13	283.8	11	187.9	2	112.0	1	6.4
Сумын дүн		757	12,018.5	580	8,615.1	29	1,071.0	119	1,954.3
25	Аймгийн ОНХС	100	7,635.2	93	6,973.1	2	184.0	5	352.5
Нийт дүн		857	19,653.7	673	15,588.2	31	1,255.0	124	2,306.8

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл 79.3 хувьтай байгаа нь төлөвлөлт бодитой хийгдээгүй, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг хүрэлцээгүй, малын тоо толгойн албан татварын орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй, улирлын чанартай ажлыг бүрэн хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулсан зэрэгтэй холбоотой байна.

ОНХС-ийн гүйцэтгэлийг аймаг, сумдаар авч үзвэл:

График-2





График-3



Баянхайрхан сумын иргэн Д.Баттөр, Я.Батцоож нараас 2024 оны 05 сарын 02-ны өдөр ирүүлсэн өргөдлийн дагуу тус сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэнээр тайлагнагдсан 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сайн усны гол дээр гүүр барих", 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Шургуугийн гол дээр гүүр барих" ажлуудыг аудитын явцад газар дээр нь үзэж, холбогдох албан тушаалтнаас тайлбар тодруулга авч, зарцуулалтын анхан шатны баримтыг шалгахад залилангийн эрсдэлтэй, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн Иргэний танхим тохижуулах 19.0 сая төгрөгийн ажлыг "Эхлэл шинэчлэлт прожект" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр санхүүжилтийг бүрэн олгосон боловч танхимын тохижилт болон тавилга, тоног төхөөрөмж 12 дугаар сард нийлүүлэгдсэн байна. Нийлүүлэгдсэн тавилга, тоног төхөөрөмж нь санхүүжилт бүрэн шилжүүлснээс хойш 8 сарын дараа

нийлүүлэгдсэн, зах зээлийн үнээс хэт өндөр байгаа нь залилангийн эрсдэлтэй байж болзошгүй тул хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ТЭЗҮ хийгдээгүйгээс төсөвт өртгийг зах зээлийн үнээс бага төлөвлөсөн, санхүүжилт оройтсон, эрт хүйтэрсэн гэх шалтгаанаар дараах ажлууд гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Алдархаан, Баянтэс, Баянхайрхан, Сонгино, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 84.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр “Гранд инженеринг” ХХК шалгарч, оны эцэст санхүүжилтийг барьцаа дансанд төвлөрүүлсэн бөгөөд гүйцэтгэгч компанийн зүгээс санхүүжилт хүрэлцэхгүй гэх шалтгаанаар тус ажил хийгдэх боломжгүй болсон байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Их-Уул сумын ЗДТГ-т эрх шилжсэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд элсний нүүдлийг сааруулах хаалт хийж мод, жимс жимсгэнэ тарих 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Далай цагаан уул” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 80.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Их-Уул сумын ОНХС-ийн хөрөнгөөр Баян-Ухаа багийн нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх 15.0 сая төгрөгийн ажлыг иргэн Д.Мөнхсайханаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Тэс сумын ОНХС-ийн хөрөнгөөр Улсын тэргүүний сум арга хэмжээний хүрээнд бетон зам өргөжүүлэх 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг иргэн Ш.Баярмагнайтай гэрээ байгуулж, 10.0 сая төгрөгөөр цементээ татсан боловч ажил одоог хүртэл эхлээгүй, мөн Сумын төвийн доод халуун усны байр засварлах 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг иргэн М.Мөнхтогтохоор гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 7.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил одоог хүртэл бүрэн дуусаагүй, гэмт хэргийн гаралтыг бууруулах, хогийн цэгийг камержуулах 14.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Тэс борхын шугуй” ХХК болон иргэн Т.Даваадоржтой гэрээ байгуулж, 13.95 сая төгрөгөөр камер худалдан авсан боловч одоог хүртэл байрлуулаагүй байна.
- Тосонцэнгэл сумын ОНХС-ийн хөрөнгөөр Хогийн цэгт шороон далан байгуулах 19.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Завхан-А33А” ТӨХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 15.9 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй, гэрээг сунгаж байгуулаагүй, Нутгийн удирдлагын ордны баруун зүүн талын авто зогсоолыг тэгшилж засах 9.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг тээврийн хөлсөнд 3.3 сая төгрөгийг зарцуулж, 6.6 сая төгрөгөөр “Мак цемент” ХХК-аас цемент худалдан авсан боловч ажил одоог хүртэл бүрэн хийгдээгүй, Сумын төв доторх хатуу хучилттай зам дээрх цагаан шугам хурд сааруулагч, явган хүний гарц бүхий хэсгийг модруулах будах 19.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Завхан-А33А” ТӨХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа 15.8 сая төгрөгийг олгосон боловч ажил хангалтгүй хийгдэж, ажлын хэсэг хүлээн аваагүй байна.
- Тосонцэнгэл сумын ОНХС-ийн хөрөнгөөр Хожуулын голын гүүрийг засварлах 190.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Завхан-А33А” ТӨХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа 149.9 сая төгрөгийг олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй тул санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгч, хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.
- Ургамал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн “Төгсөгчдийн ногоон төгөл тохижуулах” 19.9 сая төгрөгийн, “Тэрбум мод аян”-ы хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх 9.3 сая төгрөгийн ажлыг тус тус гүйцэтгүүлэхээр “Мэдээллийн эрин үе” ХХК-тай гэрээ байгуулж, урьдчилгаа 19.4 сая төгрөг олгосон боловч тус ажлууд гэрээний хугацаанд хэрэгжээгүй, гэрээг сунгаж байгуулаагүй, одоог хүртэл хийгдээгүй байна.

- Отгон сумын Хүүхдийн тоглоомын талбайд иж бүрэн гулсуур авах 10.0 сая төгрөгийн ажлыг “Евро Плэй” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 6.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил одоог хүртэл бүрэн хийгдээгүй, Онц багт мал угаалгын ванн барих 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг иргэн Б.Жамъянгаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 8.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч одоог хүртэл бүрэн хийгдээгүй, хогны менежментийг сайжруулах 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Буман төмөрт шийдэл” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон боловч гүйцэтгэлийн баримт байхгүй, хүлээж аваагүй, ажил бүрэн хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна.
- Баянхайрхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн Хойд тэвхэний худаг гаргах 60.0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй ажлыг “Стар ус” ХХК-тай гэрээ байгуулж, 45.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй, гэрээг 2024 оны 06 сарын 01-ний өдөр хүртэл сунгасан боловч тус ажил одоог хүртэл хийгдээгүй;
- Баянтэс сумын Жавхлан багийн мал угаалгын ванн болон малын тарилгын хашаа сэргээн засварлах ажилд 4.5 сая төгрөгийн, Сантмаргаз сумын төвийн гудамж, зам талбайн хаягжуулалтын ажилд 9.8 сая төгрөгийн, мөн Эрдэнэхайрхан сумын Соёлын төвийн хайс хамгаалалт хийх ажилд 5.6 сая төгрөг, цагдаагийн кабоны барилгын гадна халаалтын ажилд 9.0 сая төгрөгийн урьдчилгаа тус тус олгосон хэдий ч ажлууд нь дутуу, одоог хүртэл дуусгаагүй байна.
- Цэцэн-Уул сумын Жаргалант багийн төвийн байр барих 17.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, Эрдэнэхайрхан сумын Мөсөнгийн давааны зам засварлах 12.0 сая төгрөгийн ажил огт хийгдээгүй;
- Алдархаан сумын Сумын төвийн хаягжуулалтын ажлын санхүүжилт 10.0 сая төгрөгийг бүрэн олгосон боловч ажлаа хийгээгүй;
- Идэр сумын Засагтай багийн төсвийн хажууд улсын чанартай автозам дагуу “Автобусны зогсоол барих” ажлын урьдчилгаанд 38.6 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн ч гэрээт хугацаандаа ажлаа дуусгаагүй, хүлээлцээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх улирлын чанартай ажлыг бүрэн хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулдаг, гэрээ байгуулмагц санхүүжилтийг бүрэн олгодог, бодит гүйцэтгэлд үндэслэж санхүүжилтийг олгодоггүй зөрчил нийтлэг байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5, 3.4.3, 8.5 дахь заалтыг зөрчиж байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих шат шатны хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй 430.5 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2 ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь тус сангийн үр дүн, үр нөлөөг бууруулж байна.

2.2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс гарах үр дүн, үр нөлөөг урьдчилж тооцохгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2, 4.4-д “... ОНХС-ийн хөрөнгөөр барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ” гэж заасан бөгөөд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийг

дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлуудын зорилго, зорилт, хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө буурч байна.

Улиастай сумын Өндөр толгойн баруун талд малчдын шинэ суурьшлын бүст эрчим хүчний шугам татах 60.0 сая төгрөгийн ажлыг хийгдээгүй, зориулалтыг өөрчлөн ИТХ-аар баталж гүйцэтгэсэн ч ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр өгөөжийг урьдчилж тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүйгээс шалтгаалсан байна.

2.2.2 ОНХС-ийн хөрөнгийг журамд тусгагдаагүй төсөл арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулан, урсгал зардлуудыг санхүүжүүлж байгаа нь тус сангийн үр нөлөөг бууруулж, үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн буюу 0.5-10.0 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөгтэй тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, зарцуулж байгаа нь сангийн мөн чанар, үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал:

- Бэлчээрийн хортон мэрэгчдийн судалгаа хийж, ХХАА-н газарт санал хүргүүлэх, бэлчээрийн даацыг Фотомониторингийн аргаар тодорхойлж, цаг уурын бэлчээрийн төлөв байдлын ажиглалт хийх, гэрэлтүүлгийн урсгал зардал шийдвэрлэх, масс мессеж хүргэх, өвлийн бэлчээрийн явуул судалгааны ажиглалт хийх, сумын эдийн засгийн үндэс болсон мал сүрэг, хүн амын тооллого, статистикийн судалгааг нарийвчилж гарган, МИД-ийн түүвэр судалгааг чанартай зохион байгуулах, Малчдад бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөх сургалт зохион байгуулж хээлтүүлэгч малын чанарт анхаарч ихэнх ухнаас ноолуурыг шинжлүүлэх ажлыг зохион байгуулах, сум, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэх, төсөвт байгууллагын халаалт, гэрэлтүүлэг камерын урсгал засвар, Хүүхдийн цэцэрлэгийн хаалга шинэчлэлт, Хүүхдийн цэцэрлэгийн гадна хайс будах, сургуульд морин хуурын тоог нэмэгдүүлэх, Хогийн ковш машины засвар үйлчилгээ, Эрүүл мэндийн төвийн автомашин засварлах, ЭМТ зураг төсөв Цагдаагийн хэсгийн байрны урсгал засвар, ЗДТГ-ын байрны дулаалгын засвар, Соёлын төвийн дээвэр засварлах, ЕБС, спорт зааланд тоног төхөөрөмж, Сургуулийн дотуур байранд урсгал засвар хийх, Соёлын төвийн урлагийн хувцас шинэчлэх, багт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах, багуудын зам засах, Уст цэгүүдийн тоог нэмэгдүүлж, булаг, рашаан, худгуудыг хайс хамгаалалттай болгох, багт тариалангийн талбай хаших, эзмэгжүүлэлт зэрэг тухайн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой урсгал зардалд 682.6 сая төгрөг төлөвлөж, зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийг халуун ус барих, хатуу хучилттай зам, гудамж талбайн гэрэлтүүлэг тавих, цахилгаан дамжуулалтын шугамд холбох, цахилгаан хангамжийг сайжруулах, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, инженерийн хийцтэй худаг гаргах, авто зогсоол, явган хүний зам байгуулах, "City toilet" байгуулах, зам даваа засварлах, ойн нөхөн сэргээлт хийх зэрэг олон нийтэд чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн төсөл, арга хэмжээнд зарцуулж байгаа боловч Улиастай сумын 1 дүгээр сургуулийн гал тогооны агааржуулалтыг сайжруулах, Улиастай сумын 3 дугаар цэцэрлэгийн цонхны засвар, гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх, Улиастай сумын өрхийн эмнэлгүүдэд "Мобайл технологи" нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Нөмрөг сумын сургуулийн мэдээлэл зүйн танхимд тоног төхөөрөмж авах,

Орон нутгийн мэдээ мэдээллийг ДДШТВ-ийн "AIR1", "Шинэ Завхан" сувгаар дамжуулан 24 суманд нэвтрүүлэх, Яруу суманд хадлангийн талбай хаших, хүүхдийн тоглоомын талбай засварлах, мал ариутгалын хашаа авах, Улиастай сумын "Генерал" толгойд тохижилт хийх, Политехник коллежийн гал тогоонд тоног төхөөрөмж нийлүүлэх, Инженерийн хийцтэй худаг засварлах, дотуур байранд зөөлөн эдлэл авах, сумдын цэцэрлэгийн зөөлөн эдлэлийг шинэчлэх, багийн эмч нарыг унаажуулах, Улиастай сум дахь Улсын нөөцийн цэг салбарын хашааг засварлах, Сэрүүн асар барих ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг 5.0-20 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөг бүхий сумын ОНХС, тухайн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд 262.9 сая төгрөг төлөвлөж, зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэж, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж байгаа зөрчилд аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

2.3.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч 80.1 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй, үр дүнгүй болсон байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө нь тухайн орон нутгийн иргэд болон эзэмшигч, ашиглагч байгууллагын шаардлагад нийцэж, ашиглалт хэвийн байгаа эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Завханы "Улаан хальст" саримсыг газар зүйн заалттай бүтээгдэхүүн болгох ажлын хүрээнд улаан хальст саримс 4.0 сая төгрөгөөр худалдан авч, одоог хүртэл тариалаагүй, муудаж хаягдсан гэх тайлбарыг өгсөн боловч баримтаар нотлогдохгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.



Их-Уул сум ОНХС-ийн хөрөнгөөр 25.0 сая төгрөгөөр төв замын дагуу нутгийн брэнд бүтээгдэхүүний борлуулалтын 3 цэг байгуулж, ашиглах хүсэлтэй иргэдэд эзэмшүүлээгүйгээс шуурга салхинд эвдэрч, цаашид ашиглах боломжгүй болсон байна.

Алдархаан, Идэр, Цэцэн-Уул сумд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 51.1 сая төгрөгийн фитнесийн тоног төхөөрөмж худалдаж авсан бөгөөд одоогийн байдлаар ашиглаагүй, ажлын байр нэмэгдүүлээгүй байна.



2.3.2 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Аудитын явцад Алдархаан, Дөрвөлжин, Их-Уул, Тосонцэнгэл, Түдэвтэй, Баянхайрхан, Тэс сумдад ажиллаж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, хадгалалт хамгаалалтыг шалгахад хэвийн байна.

Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагуудад эзэмшүүлсэн бөгөөд аудитын нэгдсэн судалгаанаас харахад хадгалалт хамгаалалтын байдал хэвийн байна.

БҮЛЭГ 3. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ СУЛ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН ЧАНАРТ СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад тавих шат, шатны ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

3.1.1 Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын зөвлөл ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хяналтын зөвлөл нь аймгийн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлсэн гэх боловч хяналтын тайлан, баримтжуулалт хангалтгүй, хяналтын үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хяналтын зөвлөлийн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

Асгат, Завханмандал, Нөмрөг, Отгон, Тосонцэнгэл, Тэс, Түдэвтэй, Цагаанхайрхан сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хяналтын зөвлөл ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийсэн боловч хяналтыг нэр төдий хийж, тайлан, баримтжуулалт хангалтгүй байна.

Идэр сумын ИТХ-ын хяналтын зөвлөлөөс улирал тутам ажлын хэсэг байгуулагдан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудад хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцон, олон нийтэд мэдээлж ажилладаг байна.

Харин Алдархаан, Баянтэс, Баянхайрхан, Дөрвөлжин, Их-Уул, Сантмаргаз, Сонгино, Тэлмэн, Ургамал, Улиастай, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хяналтын зөвлөл ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийгээгүй нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.4 дэх заалтыг зөрчиж байна.

3.1.2 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Сумын Засаг даргын захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссыг томилж, ажил тус бүрээр хүлээн авсан ч захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ

хугацаандаа хэрэгжихгүй байх, чанарын шаардлага хангахгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах зэрэг эрсдэлтэй байна. Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

АОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийгдсэн ч улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажил хийгдэхгүй, үүрэг даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгадаггүй зөрчил арилахгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5, 9.7-д заасны дагуу 24 сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн ЗДТГ-аас баталсан удирдамжийн дагуу 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 13-ны хооронд хийж зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилтийг тооцоогүй, хяналт үр нөлөө багатай байна.

3.1.3 Сумдын ИТХ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар нийт 3,784.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 14.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,770.0 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 32 заалт зөвлөмжийг хүргүүлсэн байна. Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг судлан үзэхэд 1 заалт зөвлөмж хэрэгжээгүй, бусад шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Өмнөх аудитаар аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт өгсөн ИТХ-ын зөвлөлөөрөө дамжуулан ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил давтагдан гарсанд аймгийн ИТХ-д албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг, заавар журмын дагуу холбогдох газарт хүргүүлээгүй байна.

3.2.1 Сумд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийн тайланг гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2 дэх заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд аймгийн Засаг даргад ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг гаргаж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

3.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 478.6 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл тайлантай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон Баянтэс сумын 170.0 сая төгрөгийн халуун усны барилгыг хүлээж аваагүй, Улиастай сумын сургуулиудад 4.0 сая төгрөгийн итгэлтэй утас, Яруу суманд 20.0 сая төгрөгийн мал ариутгалын хашаа, Яруу суманд 20.0 сая төгрөгийн хадлангийн талбай, иргэдэд хүргэх төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Хот тохижилт үйлчилгээний албанд худалдаж авсан 195.7 сая төгрөгийн зам цэвэрлэгээний тоноглогсон автомашин, Их-Уул сумын Хонгор багийн төвийн 25.0 сая төгрөгийн конторын барилга Баянтэс сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 10.9 сая төгрөгийн 2 гэрэлтүүлэг, Сантмаргаз сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Сумын төвийн тохижилт, ногоон байгууламжийн хамгаалалтын 5.0 сая төгрөгийн төмөр хайс, Улиастай сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн 8.0 сая төгрөгийн малын тарилга туулгын зөөврийн төмөр хашааг зэрэг 478.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 478.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчиж, хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

Аудитын илрүүлэлт:

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 478.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зөрчилд холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2.3 Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг дутуу болон зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүсэж байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д бүрэн оруулсан байна. Харин сумдын ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д дутуу болон зөрүүтэй оруулж байна.

Алдархаан, Баянхайрхан, Сантмаргаз, Завханмандал, Улиастай, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумд 154 төсөл арга хэмжээний 2,558.6 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д дутуу болон огт мэдээлээгүй зөрчил байна.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Удирдлагын мэдээллийн систем”-д мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулж хэвших шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д дутуу болон зөрүүтэй, огт мэдээлээгүй зөрчилд сумдын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

3.2.4 ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, тендер сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн мэдээллийг тухай бүр оруулж, ил тод мэдээлсэн байна. 2023 санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 заалт зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар нийт 8,712.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,278.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 44.0 сая төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 7,384.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 131 заалт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэрээс бүрэн бүрдүүлэхээр төлөвлөсөн ч малын тоо толгойн албан татвараас төвлөрөх орлого бүрэн бүрдээгүй байна.
2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй байна.
3. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг шат шатны ИТХ-аас батлахдаа иргэдээс санал аваагүй, урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.
4. ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь тус сангийн үр дүн, үр нөлөөг бууруулж байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, журамд нийцээгүй 254.9 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
7. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
8. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 79.3 хувьтай байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 430.5 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй байна.
9. Баянтэс, Сантмаргаз, Дөрвөлжин, Алдархаан сумд ОНХС-ийн хөрөнгөөс нөөц бүрдүүлж худалдан авсан өвс, тэжээлийн орлогыг буцаан төвлөрүүлээгүй байна.
10. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч 80.1 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй, үр дүнгүй болсон байна.
11. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад тавих шат, шатны ИТХ-ын хяналт хангалтгүй байна.
12. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
13. Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь журамд заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, зөвлөмж өгч ажилласан ч хэрэгжилтийг тооцоогүй, хяналтын үр нөлөө бага байна.

14. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2023 оны төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг заавар журмын дагуу холбогдох газарт хүргүүлээгүй байна.
15. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 478.6 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
16. Сумдын ИТХ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
17. Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг дутуу болон зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүсэж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Н.ТАМИР-Т

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлахдаа урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй, зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй, тооцоо судалгаагүй төсөл, арга хэмжээг хэлэлцүүлж, батлуулахгүй байх;

СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлахдаа иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг хэлэлцүүлж батлуулахгүй байх;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР-Т

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө урьдчилсан жагсаалтад тусгагдсан, зураг төсөвтэй, техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хийгдсэн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусган батлуулж байх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвт өртгийг тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр бодит тооцоололд үндэслэн төлөвлөх;
3. ОНХС-ийн хөрөнгийг тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх;
4. Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс ОНХС-д хийж байгаа хяналт шинжилгээ үнэлгээний үр нөлөөг сайжруулж, хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллах;
5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумдаас авч нэгтгэн, журамд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлж байх;

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн санал авч эрэмбэлсэн, зураг төсөвтэй, техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хийгдсэн төсөл, арга хэмжээг тусган батлуулж байх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авах саналын тоо, хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах;

3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвт өртгийг тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр бодит тооцоололд үндэслэн төлөвлөх;
4. ОНХС-ийн хөрөнгийг тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх;
5. Малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнд хурааж, ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлэх;
6. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах;
7. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг "Удирдлагын мэдээллийн систем"-д үнэн зөв, иж бүрэн оруулж, иргэд олон нийтэд ил тод, нээлттэй хүргэж байх;

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.dhg@gmail.com

2024. 07. 05 № 6/652


төний -ны №

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар 4,0 сая төгрөгийн саримсны нөөц бүрдүүлж лааны буланд тариалсан боловч 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улиастай суманд орсон хүчтэй борооны улмаас үерт автаж устгалд оруулсан.

Иймд төлбөрийн акт тогтоох тайлангийн хэсгээс хасч актаас чөлөөлж өгнө үү.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  ДАЗЖАРГАЛ



Doc toot a5

0173090926

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Завханы **"Улаан хальст"** саримсыг газар зүйн заалттай бүтээгдэхүүн болгох ажлын хүрээнд 4.0 сая төгрөгөөр улаан хальст саримс худалдан авч, үр дүнгүй болсон зөрчилд тогтоосон төлбөрийн актыг чөлөөлүүлэх санал, хүсэлт ирүүлснийг аудитын баг хэлэлцээд баримтаар нотлогдохгүй байгаа тул төлбөрийн актыг хэвээр үлдээхээр шийдвэрлэлээ.